



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТСУУРЬ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023. 11. 16 № ХТ/2536
танай _____-ны № _____-т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын төслийн асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Эрчим хүчний сайдаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт /... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000235024841





**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2023.11.10 № а/3783.
танай 2023.11.03. -ны № хэр/2460 -т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН ТАНАА**

Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай
дулааны цахилгаан станцын төслийн асуудлаар
Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их
Хурлын гишүүн Ж.Батсуурийн асуулгын хариуг
хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600001236

Монгол Улсын Засгийн газрын

Хэрэг баримт газар

Бичиг хэрэг

Огноо 2023.11.15

16 цаг 00 минут

Эрчим хүчний сайдын
2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн
а/з/кз тоот албан бичгийн хавсралт

“ТАВАНТОЛГОЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨСЛИЙН ТАЛААР

Асуулга 1: Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад хүлээлгэн өгөх төслийн ажлын явц, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

Хариулт:

Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Бүтээн байгуулалтын томоохон төсөл хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 71 дүгээр тогтоолоор төсөл хэрэгжүүлэх төслийн нэгжийг байгуулах, санхүүжүүлэх, төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, холбогдох судалгааг хийлгэх үүргийг өгсөн. Ийнхүү Эрчим хүчний сайдын 2013 оны 36 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх Тавантолгойн цахилгаан станц төслийн нэгж байгуулагдаж байсан.

Төслийн бэлтгэл шатанд төслийн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид шалгарч Монгол Улсын Засгийн газар, төслийн компани болох “Тавантолгой цахилгаан станц” ХХК болон “М-Си-Эс Пауэр” ХХК-ийн хооронд Тавантолгой цахилгаан станц төслийн хөрөнгө оруулалтын гэрээг 2016 оны 06 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан.

Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авах замаар босгох нөхцөлийг бүрдүүлэхэд ирээдүйн гол хэрэглэгч болох “Рио Тинто” ХК-ийн эрчим хүчний төлбөрийн баталгаа гаргах, “Оюу толгой” ХК болон “Тавантолгой цахилгаан станц” ХХК-ууд эрчим хүч худалдах, худалдан авах үнийг харилцан тохиролцох асуудал шийдэгдээгүйн улмаас 2016 оноос төсөл хүлээлтийн байдалд орсон бөгөөд төслийн хөгжүүлэлтийн үе шат удаашралтай байсан тул 2017 онд гадаадын хөрөнгө оруулагч Марубени корпораци төслөөс гарч байгааг мэдэгдсэн байдаг.

Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 124 дүгээр тогтоолоор Өмнөд бүсийн уул уурхайн болон Оюутолгой төслийн эрчим хүчний хэрэгцээг хангах зорилгоор цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх Төрийн өмчит “Тавантолгой дулааны цахилгаан станц” ХХК-ийг байгуулж, төслийн санхүүжилтийг үе шаттайгаар шийдвэрлэхийг Сангийн яам, “Эрдэнэс Тавантолгой” ХК-д даалгасан.

Тогтоолын дагуу “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК нь 2020 оны 10 дугаар сард байгуулагдан төслийн бэлтгэл ажлыг хангаж, төслийг эхлүүлэхээр ажиллаж байна.

Төслийн хүрээнд дорд дурдсан барилга байгууламжууд баригдана. Үүнд:

- Гурван блок бүхий 450 (3x150)МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц ашиглалтад оруулна.

- Тавантолгой, Оюутолгой дэд станц руу чиглэсэн 2 хэлхээ 220 кВ-ын 167км цахилгаан дамжуулах агаарын шугам (ЦДАШ), дэд станц барьж байгуулна.
- Станцын ус хангамжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

Төслийн бэлтгэл ажлын тухай:

1. Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын хүрээнд:

Тавантолгойн 450МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөлөөр 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан ба Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 132 дугаар тогтоолын дагуу Тавантолгойн 450МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын техник эдийн засгийн үндэслэлийг 300+150МВт хүчин чадалтай 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр болсон тул шинэчлэн Эрчим хүчний яамны Шинжлэх Ухаан Технологийн Зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.

2. Цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд:

Тавантолгой дулааны цахилгаан станцын үйлдвэрлэсэн эрчим хүчийг дамжуулах шугамын зураг төслийг Эрчим хүчний яамнаас олгогдсон цахилгааны техникийн нөхцөлийн дагуу 2021 онд “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨАТҮГ-аар зураг төслийг хийж гүйцэтгүүлсэн. Үүнд:

- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт баригдах дулааны цахилгаан станцыг эрчим хүчээр хангах нэгдсэн сүлжээний 220/110/35 кВ-ын “Тавантолгой” дэд станцтай 220 кВ-ын ЦДАШ-аар холбох, 220/110/35 кВ-ын дэд станцын өргөтгөлийн ажлын зураг төсөл;
- Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт баригдах дулааны цахилгаан станцыг эрчим хүчний нэгдсэн сүлжээний 220/35 кВ-ын “Төв” дэд станцтай 220 кВ-ын ЦДАШ-аар холбох ажлын зураг төсөл;
- 220/110/35 кВ-ын “Тавантолгой” дэд станцын ИХБ-220 кВ-ын өргөтгөл, 220 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ-ын ажлын зураг.

3. Дулааны цахилгаан станц болон ЦДАШ-ын газрын асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тавантолгой дулааны цахилгаан станц барих газар эзэмших эрх 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр олгогдож, нийт 90.23 га хэмжээтэй, Э-1114000337, Э-1114000335 улсын бүртгэлийн дугаартай гэрчилгээ олгогдсон. Газар эзэмших гэрээг байгуулж гэрээний дагуу газрын төлбөрийг төлж байна.

Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын 2 хэлхээ 167 километр цахилгаан дамжуулах агаарын шугамын трасс Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч байгаа тул дээрх сумдын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгуулсан. Мөн 2023 онд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 3-р багт байрлалтай 2 нэгж талбарын нийт 90,2 га газарт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдэж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраар баталгаажуулах ажил хийгдсэн.

4. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авах ажлын хүрээнд:

“Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК -нд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлаар №01/2021 дугаар бүхий эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг олгосон.

5. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын хүрээнд:

Тавантолгой 450МВт-ын дулааны цахилгаан станц төслийн болон Тавантолгой-Оюутолгой чиглэлийн 220кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сумдын иргэд, олон нийтэд танилцуулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжлийн зөвлөлөөр 2022 оны 04 дүгээр сард батлуулсан.

6. Станцын ус хангамжийг шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тавантолгой 300 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станцын усны хэрэглээ нь жилд 780,000 м³, секундэд 21,8 л орчим байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны “Галба-Өөш долоодын говийн сав газар”-аас 2021 онд төслийн ус хангамжийг шийдвэрлэх Наймдайн хөндийн газрын доорх усны ордоос ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар 5 жилийн хугацаатай ус ашиглах зөвшөөрөл авсан.

Мөн Усны газрын зөвлөмжийн дагуу 2022 онд “Загийн усны хоолой” газрын доорх усны ордод станцын ус хангамжийг нэмэгдүүлэх, усны нөөцийг нарийвчлан тогтоох эрэл хайгуул, судалгааны ажлыг хийж гүйцэтгэж 25 жилийн хугацаатай үйлдвэрлэлийн зориулалттай 13л/с усны нөөцийг тогтоож, Байгаль орчин аялал жуулчлалын яамны “Усны нөөцийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулаад байна. 2023 онд “Загийн усны хоолой”-н газрын доорх усны ордын нөөцийг нэмэгдүүлэх, хайгуул судалгааны ажлыг үргэлжлүүлэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хэрэгжүүлж буй “Загийн усны хоолой” төслийг өргөтгөх байдлаар Тавантолгой дулааны цахилгаан станцын ус хангамжийг шийдвэрлэхээр ажиллаж байна. Түүнчлэн ойрын хугацаанд хэрэгжих “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цагаанцав усны эх үүсвэрийг ашиглах ТЭЗҮ-д Тавантолгой дулааны цахилгаан станцын усны хэрэглээг тусгуулж, төслийн усны хэрэглээг баталгаажуулсан болно.

7. “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ” байгуулах ажлын хүрээнд:

Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Оюу толгойн уурхайг урт хугацаанд “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-г 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК болон “Оюу толгой” ХК-ийн хооронд байгуулсан. Оюу толгой уурхайн эрчим хүчний хэрэглээний оргил ачаалал нь 285МВт, дундаж ачаалал нь 236МВт орчим байх бөгөөд Тавантолгойн 300МВт-ын дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор тус хэрэглээг дотоодын эх үүсвэрээс бүрэн хангах боломжтой болно.

“Диспетчерийн үндэсний төв” ТӨХХК, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн хамтарсан Ажлын хэсэг нь Тавантолгой дулааны цахилгаан станцаас “Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ”-ний төслийг боловсруулж төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй ЕРС+F гэрээ баталгаажсан нөхцөлд гэрээг байгуулахаар ажиллаж байна.

8. Станцын нүүрс хангамжийг шийдвэрлэх ажлын хүрээнд:

Тавантолгой дулааны цахилгаан станцын ашиглалтын үед хэрэглэх эрчим хүчний нүүрсний төрөл, нүүрсний чанарын үзүүлэлт, нүүрсний тоо хэмжээ болон нүүрс хадгалах талбайн нөөцийн хэмжээ, нүүрсний суурь илчлэгээр нэгж илчлэгийн үнэ тооцох асуудлыг харилцан тохиролцож, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн хооронд “Нүүрс нийлүүлэх гэрээ”-г 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан.

9. Станцын үнс хаягдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:

Төслийн ТЭЗҮ-д тусгагдснаар дулааны цахилгаан станцаас ялгарах үнсийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхайн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан хөрсний овоолго руу машинаар тээвэрлэн далдлан булахаар тусгагдсаны дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн хооронд “Хаягдал үнс булах гэрээ”-г 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан.

10. “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” байгуулах ажлын хүрээнд:

“Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн үйл ажиллагааны зорилго, үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргах, худалдах, худалдан авах, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн оруулах хөрөнгийн хэмжээ, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, талуудын хамтран ажиллах зарчим, компанийн үйл ажиллагааг явуулахтай холбоотой үүсэх харилцаанд хувьцаа эзэмшигчдийн эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлага, хамтран ажиллах журмыг тодорхойлсон “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хооронд байгуулагдсан.

11. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд хүрээнд:

“Эрдэнэс Тавантолгой” ХК-тай “Санхүүжилт, хөрөнгө оруулалтын гэрээ”, “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ”, “Нүүрс нийлүүлэх гэрээ”-ний төслийг талууд хамтран боловсруулах, гэрээг байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Хамтарсан ажлын хэсэг “Тавантолгой дулааны цахилгаан станц” ТӨХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулах “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг боловсруулах, төслийн нийт хөрөнгө оруулалтын 30 хувийг шийдвэрлэх “Эрдэнэс Тавантолгой” ХК-тай байгуулах “Санхүүжилтийн гэрээ”-ний төслийг тус тус боловсруулан ажилласан бөгөөд төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, түлхүүр гардуулах нөхцөлтэй ЕРС+F гэрээ байгуулагдсанаар төслийн хөрөнгө оруулалтын нийт дүн тодорхойлогдох учраас дээрх гэрээнүүдийг баталгаажуулах ажил хүлээгдэж байна.

12. Тавантолгой дулааны цахилгаан станцыг барьж байгуулах гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын хүрээнд:

Тавантолгой дулааны цахилгаан станцын барилга угсралтын ажлын ерөнхий

гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны бэлтгэл ажлыг ханган, холбогдох материалуудыг бэлтгэн, техникийн ерөнхий болон нарийвчилсан шаардлага, хавсралт материалуудыг боловсруулсан.

13. Хөгжлийн банкны зээлийн төлбөрийг шийдвэрлэх ажлын хүрээнд:

Эрчим хүчний яам, Эдийн засгийн хөгжлийн яам болон Хөгжлийн банкны хооронд 2014 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр байгуулсан 3-ДЦ-Б2014-30 дугаартай "Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах" гэрээний хүрээнд төслийн нэгжид олгосон 14.8 сая ам.долларын зээлийн зарцуулалтыг нягтлах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж, өмнөх төслийн нэгжийн архивын баримтад тулгуурлан судалгааг хийснээр 5 зөвлөмж бүхий тайлан боловсруулж, Эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Эрчим хүчний яам тус саналыг харгалзан үзэж, зээлийн гэрээний хугацааг сунгуулах хүсэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр Хөгжлийн банканд хүргүүлсэн ба Хөгжлийн банкны зүгээс гэрээний хугацааг сунгах боломжгүй тухай мэдэгдсэн.

Дээрх зээлийн гэрээний хүрээнд төслийн нэгжид олгосон 14.8 сая ам.долларын зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн өр төлбөр Эрчим хүчний сайдын 2020 оны 166 дугаар тушаалаар 2020 оны 09 дүгээр сараас эхлэн компанийн балансад бүртгэгдэж ирсэн бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулснаар 17,629,486.59 (Арван долоон сая зургаан зуун хорин есөн мянга дөрвөн зуун наян зургаан ам.доллар 59 цент) ам.доллар буюу 60,989,208,858.11 (Жаран тэрбум есөн зуун наян есөн сая хоёр зуун найман мянга найман зуун тавин найман төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үндэсний аудитын газраас Эрчим хүчний яаманд энэхүү гэрээнд заасан зээлдэгчийн эрх үүргээ хэрэгжүүлэх, зээлийг төлж барагдуулах тухай 3 удаагийн албан шаардлага ирүүлсэн болно.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолын 3-т "Төслийн 300МВт-ын I үе шатны (EPC+F) гэрээний 30 хувийг санхүүжүүлж, "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлыг хариуцаж, Монгол Улсын хөгжлийн банкнаас Тавантолгой дулааны цахилгаан станц төсөлд олгосон зээл, зээлийн хүүгийн үлдэгдлийг төлөх, эдгээр зардлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК болон төрийн өмчийн хувь эзэмшилд оруулж тооцохыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Ганбат)-д даалгасан.

Төслийн 30%-ийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гэрээ болон төслийг санхүүжүүлэхтэй холбогдуулан авах төслийн зээл, санхүүгийн бусад хэлцэлтэй холбогдон баталгаа гаргах талаар ЭХЯ, ТӨБЗГ, "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн төлөөлөл бүхий хамтарсан ажлын хэсэг Эрчим хүчний сайдын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Асуулга 2: Тавантолгойн дулааны цахилгаан станцын төслийн ажил яагаад өнөөдрийг хүртэл хойшилсон, хэзээ бүрэн ашиглалтад орохоор төлөвлөж байгаа, энэ талаар хэрэгжүүлж буй ажлын талаар;

Асуулга 3: Тус төслийн тендер шалгаруулалтын талаар болон дээр дурдсан Камбож Улсын компани урьдчилсан байдлаар шалгарсан гэх мэдээлэл үнэн бодитой эсэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

Тайлбар: Асуулга 2, 3 агуулгын хувьд давхцаж байгаа тул хариултыг нэгтгэн бичив.

Хариулт:

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр 2021 оны 10 дугаар сар болон 2022 оны 5 дугаар сард тус тус зарласан. Тухайн тендерүүдэд тус бүр нэг оролцогч оролцож, тендерийн шаардлага хангаагүй тул тендер амжилтгүй болсон. Тендер амжилтгүй болсон болон тендерт оролцогчдын сонирхолыг татаагүй шалтгааныг судлан үзэхэд дараах асуудлууд байсан. Үүнд:

- 1) Тендерт оролцогч компаниуд нь төслийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, төлбөрийг нүүрсээр авах OFFTAKE нөхцөлтэй санал ирүүлсэн нь Монгол Улсын Засгийн газраас нүүрсийг барьцаалах буюу нүүрс борлуулсан орлогоор санхүүжих OFFTAKE гэрээг хязгаарлах арга хэмжээтэй давхцаж, тус нөхцөлөөр цаашид төслийг хэрэгжүүлэх боломжгүй байдалтай тулгарсан.
- 2) 2021 оны 09 дүгээр сард зохион байгуулагдсан НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганд БНХАУ-ын Ши Жиньпин дарга Хятад улс нь гадаад улс оронд хатуу түлшээр галладаг цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төслийг санхүүжүүлэхгүй гэж мэдэгдсэн. Үүний дагуу БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос төрийн өмчит компаниудад гадаад улс оронд нүүрсээр ажилладаг цахилгаан эрчим хүчний шинэ эх үүсвэрийн төсөлд санхүүжилт хийхгүй зөвхөн барилга угсралтын ажилд туслан гүйцэтгэгчээр оролцох хязгаарлалт тавьсан байна. Тодруулбал, БНХАУ-ын Dongfang Electric International Corporation (DECI) компаниас МУ-ын Ерөнхий сайдад ирүүлсэн 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн DECI/MNG/TT-004 тоот албан бичигт Тавантолгой дулааны цахилгаан станцын төслийн барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр ажиллах боломжгүй, зөвхөн туслан гүйцэтгэгчээр ажиллах талаар дурдаж, хамтран ажиллах сонирхолоо илэрхийлсэн байдаг.
- 3) Дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан нүүрсээр ажиллах цахилгаан станцын төслийг санхүүжүүлэхээс Засгийн газрууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагууд татгалзаж НҮБ-ын хүрээлэн буй орчны хөтөлбөрийн хүрээнд дэлхийн 43 банк, санхүүгийн байгууллага 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр “0 хүлэмжийн хийн банкнуудын холбоо”-г үүсгэн байгуулсан байна. Тус холбоонд одоогийн байдлаар нийт 41 улс орны 125 банк, санхүүгийн байгууллага гишүүнээр элсэн орсон бөгөөд гишүүд нь 2050 он гэхэд олгосон зээл, хөрөнгө оруулалтын багцад байх төсөл, хөтөлбөрүүдийн хүлэмжийн хийн ялгарлыг 0-д хүргэх амлалтыг авсан байна. Үүнээс шалтгаалан тендерт оролцогчид нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцын төсөлд санхүүжилт босгоход хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан Засгийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанд “Тавантолгой дулааны цахилгаан станц төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулж, 132 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолд:

- Тавантолгой дулааны цахилгаан станцын төслийг 300МВт+150МВт гэсэн 2 үе шатад хуваан, эхний ээлжид 300МВт-аар ашиглалтад оруулах;
- Төслийн барилга угсралт болон санхүүжүүлэх эх үүсвэрийг хамтатгасан (EPC+F) хэлбэрээр сонгон шалгаруулах;
- Төслийн 300МВт-ын I үе шатны (EPC+F) гэрээний 30 хувийг санхүүжүүлэх;
- Төслийн 70 хувийг санхүүжүүлэхтэй холбогдуулан авах төслийн зээл, санхүүгийн бусад хэлцэлтэй холбогдон баталгаа гаргах, холбогдох бусад үүргийг хүлээхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-д тус тус үүрэг болгосон.

Уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ЭХЯ-наас Тавантолгой дулааны цахилгаан станцын төслийн тендерийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох бараа, ажил, үйлчилгээний хэмжээг хязгаарлахгүй байх, туслан гүйцэтгэгчийн туршлагыг тендерт оролцогчийг үнэлэх үнэлгээнд оруулж тооцох зөвшөөрөл авах хүсэлтийг Сангийн яаманд 2023 оны 05 дугаар сард хүргүүлсэн.

Үүнтэй холбогдуулан Сангийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/118 дугаар “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” тушаалаар тендерийн жишиг баримт бичигт “... түлхүүр гардуулах гэрээгээр гүйцэтгүүлэхээр бүхэлд нь тендер шалгаруулалт зарлах бол тендер шалгаруулалтын зааварчилгааны 5.1, 5.2-т заасан туслан гүйцэтгүүлэх дээд хэмжээ болон түншлэлийн гишүүн тус бүрийн үүргийн доод хэмжээг тендерийн өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно” гэсэн өөрчлөлтийг оруулсан.

Тус тушаалыг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулж, Эрчим хүчний яамнаас ЭХЯ/202306001 дугаартай, Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих Тавантолгой 450МВт-ын дулааны цахилгаан станцын эхний ээлжийн 300МВт-ын гүйцэтгэгч болон санхүүжүүлэх эх үүсвэрийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зарлаж, 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр нээсэн.

Тендерт дараах 2 оролцогч оролцсон. Үүнд:

- Камбожийн Хаант Улсын “Митайм Интернэйшнл” ХХК (Mitime International Co.,Ltd) нь БНХАУ-ын PowerChina Hebei Electric Power Engineering компанитай зураг төсөл, төслийн менежмент, техникийн дэмжлэг үзүүлэх болон БНХАУ-ын China energy engineering group Heilongjiang energy engineering компанитай техникийн удирдлага, инженерийн үйлчилгээ үзүүлэх туслан гүйцэтгэгчийн гэрээг тус тус байгуулсан. Мөн БНХАУ-ын цахилгаан станцын үндсэн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч 8 компанитай тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг байгуулсан тендерийн санал ирүүлсэн.
- БНХАУ-ын “Чайна вэстэрн павр индастриал” ХК (China Western Power Industrial Co.,Ltd), “Бээжин бэйжонг уурын турбин генератор” ХХК (Beijing Beizhong Steam Turbine Generator Co.,Ltd), Монгол Улсын “Майнс Ан” ХХК-ийн түншлэлээс тус тус тендерт санал ирүүлсэн.

Тендерт Камбожийн Хаант Улсын “Митайм Интернэйшнл” ХХК-ийг шалгаруулж, зөвлөмж хүргүүлсэн боловч тендерт шалгараагүй түншлэлээс Сангийн яаманд удаа дараа гомдол гаргасан.

Гомдлын дагуу Сангийн яамнаас тендерийг түр түдгэлзүүлж, тендерийг дахин үнэлэх чиглэлийг өгсөн ба тендерийн хүчинтэй хугацаанд багтаан үнэлгээ хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах боломжгүй болсон тул тус тендер хүчингүй болсон байна.

Төслийн бүтээн байгуулалт, барилга угсралтын ажил төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулагдсанаас хойш 36 сарын хугацаанд үргэлжлэх бөгөөд Тавантолгой 300МВт-ын дулааны цахилгаан станцын төслийг 2024-2027 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй байна.

Асуулга 4: Уг станц ашиглалтад орсноор Монгол Улсын нийгэм, эдийн засаг, ард иргэдэд үзүүлэх үр өгөөжийн талаарх мэдээлэл;

Хариулт:

Тавантолгой дулааны цахилгаан станц нь ашиглалтад орсноор Монгол улсын нийгэм эдийн засаг, ард иргэдийн амьдралд эерэг нөлөө үзүүлэх өндөр ач холбогдолтой төсөл юм. Үүнд:

- Тавантолгой дулааны цахилгаан станц 300МВт-ын хүчин чадлаар ажиллахад Монгол Улсын төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 1.88 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх буюу Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний нийт хэрэглээний 20 орчим хувийг нийлүүлэх юм.
- Тавантолгойн 450МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц жилд 7,572 цаг ажиллахад 1 кВт.ц цахилгаан үйлдвэрлэх өөрийн өртөг 6.27 цент/кВт.ц буюу өнөөгийн импортын цахилгааны үнээс 1.43 дахин бага үнэтэй эрчим хүч үйлдвэрлэх ба төслийн дотоод өгөөжийн хувь нь 15.04 хувь байна.
- Тавантолгой дулааны цахилгаан станц нь өөрийн үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлогоос төсөлд зарцуулсан хөрөнгө оруулалтыг 9 жилийн хугацаанд нөхөж, жил бүр 90-100 сая.ам долларын цэвэр ашигтай ажиллах санхүү, эдийн засгийн тооцоолол хийгдсэн.
- Говийн бүсийн стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, тэдгээрийг дотоодын эрчим хүчний системээс хангаж, импортын эрчим хүчний хэрэглээг хязгаарлан жилд 120-140 сая ам.долларын гадагш чиглэсэн валютын урсгалыг дотооддоо үлдээж, улс болон орон нутгийн төсөвт жилд 34.5 сая ам.долларын татвар, хураамжийг төвлөрүүлнэ.
- Тавантолгой дулааны цахилгаан станц нь Тавантолгойн нүүрсний орд газрыг түшиглэн баригдах тул нүүрсийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.
- Тавантолгой дулааны цахилгаан станцын барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2500-3000 хүн ажиллаж, Тавантолгой дулааны цахилгаан станц нь эхний 300МВт ашиглалтад орсноор байнгын 220 ажлын байр шинээр бий болно.
- Тавантолгой дулааны цахилгаан станцын техник технологи нь хамгийн найдвартай туршигдсан, өндөр үр ашигтай, Дэлхийн банкнаас тавьсан байгаль орчны шаардлагуудыг хангасан, усны хэрэглээ багатай, химийн хорт хаягдалгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай, шинэ техник технологи нэвтрүүлсэн цахилгаан станц болно.
- Станцын ашиглалтын үед ялгарах утаанд агуулагдах хорт хий болон тоосны хэмжээ нь Монгол Улсын стандартад заасан хэмжээнээс хэтрэхгүй, энэ нь цахилгаан станцад технологийн сүүлийн үеийн шийдлүүдийг ашигласнаар

тухайн орчны агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх боломжтойг харуулж байна.

- Хүхрийн давхар исэл (SO_2)-ийн ялгаралыг бууруулахын тулд нүүрс шатаах явцад шохойн Чулуу нэмэхээр төлөвлөсөн. Мөн Станцын үнс барих төхөөрөмж нь хамгийн сүүлийн үеийн технологийн буюу утааг 99.8% цэвэршүүлэх зориулалттай цахилгаан фильтр суурилуулахаар төлөвлөсөнөөр байгаль орчинд ээлтэй станц болно.
- Цахилгаан станцын төслийн үндсэн тоноглолын сонголт нь орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшил, сүүлийн үеийн ололт, амжилтуудыг тусгасан эргэлдэх буцламтгай үет шаталттай зуух бүхий станц болно. Станц нь АҮК харьцангуй өндөр хөрөнгө оруулалтын зардал бага, хувьсах горимд ажиллах чадвар сайтай хорт хий ($\text{SO}_x \approx 90\%$, $\text{NO}_x \approx 50\%$)-н ялгаруулалтыг бууруулдаг зэрэг давуу талуудтай байна.
- Турбины конденсаторын төхөөрөмжийг агаарын хөргөлттэй авсан нь усны нөөц хомсдолтой говийн нөхцөлд тохирох эрс тэс уур амьсгалтай манай орны нөхцөлд өвөл, зуны улиралд зохицуулан ажиллуулах боломжтой дэвшилтэд технологи юм. Хуурай хөргөлтийн системийг хэрэглэснээр ДЦС-3, ДЦС-4 болон бусад дулааны цахилгаан станцуудад ашиглаж байгаа хөргөлтийн системтэй харьцуулахад усны хэрэглээг дунджаар 80%-аар хэмнэх боломжтой зэрэг олон давуу талтай төсөл юм.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

---oOo---